



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Тэшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2020/9/-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.bulgan@audit.mn

Булган аймаг
2020 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр
Утас:90900910 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 99057478 Цахим хаяг:Enhtsoodolj@audit.gov.mn
Гэрээт аудитор: П.Эрдэнэзул
Утас:99812414 Цахим хаяг: Erdenezulp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	8
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	10
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	11
2.13. Шилэн дансны мэдээлэл	11
2.14. Өмнөх итаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	11
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
Менежментийн захидал	13
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	15
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	15 Агуулга
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	17
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	20
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	24
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	24
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	25

Аудитын гэрчилгээ



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

᠒᠐᠒᠐.᠐3.24 № 126

танай _____ -ны № _____ т

Аудитын гэрчилгээ

ТЭШИГ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Б.БАТСАЙХАН ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д заасан Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Тэшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Тэшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Тэшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Илэрсэн алдаа зөрчил нь гүйцэтгэлийн шатанд тогтоосон материаллаг түвшнээс их, мөн харьяа байгууллагуудын төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах алдаа зөрчил илэрсэн. Үүнд:

1. ТБОНӨХБАҮХА тухай хуулийг хэрэгжүүлээгүй шууд гэрээгээр худалдан авах босго үнээс давсан хүүхдийн хоолны материалын худалдан авалтыг тендер зохион байгуулаагүй,
2. Аймгийн Засаг даргын захирамжтай давхардуулан сумын Засаг даргын захирамжаар сургуулийн өмнөх боловсролын байгууллагын эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгосон,

00602028


3. Хүүхдийн хоолны норматив зардлыг хэтрүүлэн зарцуулсан, санхүү төсвийн зүй зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүй,
4. Зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зүй зохистой, зориулалтын дагуу зарцуулаагүй,
5. Хадгаламжийн хүүгийн орлого, Ойгоос мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр, улсын тэмдэгтийн хураамж, хог хаягдал үйлчилгээний хураамж, ан амьтны нөөц ашигласны төлбөр, ашигт малтмалаас бусад баялаг ашигласны орлого, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр нийт 7 нэр төрлийн 17.3 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй тасалсан,
6. Төсвийн төвлөрүүлэн захирагч хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэтрүүлэн эрх зүйн акт гаргасан нь санхүүгийн тайлангийн "Хэмжилт", "Эрх ба үүрэг", "Тохиолдсон байх", "Үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Д.АНХБАЯР



Аудитын тайлан

2.1. Оршил

Тэшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Засаг дарга Б.Батсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тэшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тэшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 15-наас 2020 оны 03 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 24-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Булган аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор П.Эрдэнэзул хариуцаж хэрэгжүүлэв.

Тэшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 01/113 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Төрийн аудитын байгууллагаас

санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Тэшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засгийн хэтийн хөгжлийн бодлогыг орон нутгийн нөөц боломж, онцлог, улс, аймгийн бодлого, чиглэлтэй уялдуулан боловсруулж, сумын НӨУЁ Байгууллага ИТХ-ын Тэргүүлэгчид, төрийн гүйцэтгэх захиргааны байгууллага болох сумын Засаг даргыг бүрэн боловсрогдсон бодлогын зөвлөгөө дэмжлэгээр хангаж, иргэдэд чиглэсэн төрийн үйлчилгээг шуурхай үзүүлэхэд оршино.

Сумын Засаг даргын захирамжаар үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн захиргаа, төрийн албаны өөрчлөлт, шинэчлэл, тогтвортой хөгжлийн стратегитай уялдуулан нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц, төрийн захиргааны удирдлага, хүний нөөцийн удирдлага, нийтлэг үйлчилгээ, санхүүгийн удирдлагын арга барилыг боловсронгуй болгон хөгжүүлэх
- Монгол улсын хууль тогтоомжийн акт, аймаг, сумын ИТХ, Засаг даргын шийдвэр, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн орон нутгийн бодлогыг боловсруулж, хэрэгжилтийг шуурхай зохицуулалтаар хангах замаар хувийн хэвшлийг хөгжүүлэн, үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх
- Хүний хөгжлийн цэгцтэй бодлого явуулах замаар иргэдийн сурч боловсрох, эрүүл байх, урт наслах, өмч хөрөнгөтэй байх зэрэг иргэн бүрийн сонголт хийх нөхцөлийг бүрдүүлэх, зорилтот бүлгийн нийгмийн хамгаалал, халамжийн оновчтой тогтолцоог бий болгож, тэдэнд хүргэх үйлчилгээний үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн албаны тухай хууль / шинэчилсэн найруулга/
- Төсөв баталсан Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол
- Төсөв баталсан Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол
- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол Журам батлах тухай(Төрийн албан хаагчид шагнал олгох, ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн мөнгөн урамшуулал олгох)

- Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоол Журам батлах тухай(Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох)
- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол Журам батлах тухай(Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл олгох)
- Сангийн сайдын 2018 оны 9 дүгээр сарын 12 -ны өдрийн 228 дугаар тушаал (Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам)
- Сангийн сайдын 2007 оны 11 дугаар сарын 30 -ны өдрийн 326 дугаар тушаал (Журам батлах тухай Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Төсвийн байгууллагууд нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд STS программ хангамж ашигладаг байна.

Тэшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Тэшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 3 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 3284366153,5 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 65687323 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 65687323 мянган төгрөгөөр тооцлоо.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Тэшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 591288.3 мянган төгрөгөөр буюу 5.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	127704,3	42622,9	- 85081,4
Авлага	217690,9	288502,3	70811,4
Урьдчилгаа			
Бараа материал	323554,3	358152,7	34598,3
Үндсэн хөрөнгө	3206442,4	3053533,9	-152908,4
Нийт хөрөнгө	3875391,9	4092811,9	217420,0
Өр төлбөр	180106,0	154666,7	-25439,3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3695285,9	3588145,2	-107140,7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3875391.9	3742811.9	-132580.0

Авлага дансны үлдэгдэл 70811.4 мянган төгрөгөөр өссөн нь СХСангийн зээл, Сургууль ХАОАТ татвар илүү шилжүүлсэн, ЭМТөв нь эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн авлагаас шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2003 оноос өмнөх онуудад үүссэн, он удаан жил болсон 21987.2 мянган төгрөгийн байгууллагаас /хувь хүнээс/ авах авлага байна. Үүнээс эзэн холбогдогч нь тодорхойгүй шалтгааны улмаас барагдах боломжгүй, эрсдэлтэй 9765.0 мянган төгрөгийн авлага байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг зөрчиж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 34598.3 мянган төгрөгөөр өссөн нь 345532.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, үнэ төлбөргүйгээр 18453,1 мянган төгрөгийн бараа материал орлого авч 329386,8 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан байна. 2019 онд бусад хангамжийн материалд Сургууль 12616.0 мянган төгрөг, Цэцэрлэг 16143.9 мянган төгрөг, Соёлын төв 6842.0 мянган төгрөг, мөн Сургууль хүнсний материалд 16212.8 мянган төгрөгийн худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь бараа материалын үлдэгдлийг өсгөсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 197091.5 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалт болон хандив, үнэ төлбөргүй хүлээн авсан нь шалтгаалжээ. Хөрөнгө оруулалтаар 614178.2 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 13904.3 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 36854.3 мянган төгрөг, акталсан хөрөнгө байхгүй байна.

Биет бус хөрөнгөнд өөрчлөлт ороогүй байна.

Нийт өр төлбөр дансны үлдэгдэл 25439,3 мянган төгрөгөөр нь буурсан нь Тэшиг ус 15705,1 мянган төгрөгөөр, ЭМТөв 2168,5 мянган төгрөгөөр нэмэгдэж, ОНХСан 17029,3 мянган төгрөг, ЭЭСан 19358.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь шалтгаалжээ.

Урт хугацаат өр төлбөр 9620.7 мянган төгрөгөөр буурсан. Тэшиг Ус банкны зээл өр байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 2017-2019 онуудын 37160.0 мянган төгрөгийн нийт өр төлбөрийн 24 хувийг эзэлж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3938145.2 мянган төгрөг болж 242859,3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 2060.4 мянган төгрөгийн бичилт нь Тэшиг ус ОНӨ ХХК өмнөх оны авлагын зөрүү -9843.2 мянган төгрөг, сургууль барилгыг ЗДТГазарт шилжүүлсэнтэй холбоотой 11903.6 мянган төгрөгийн бичилт хийсэн байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Тэшиг сум нь тайлант онд 148203.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 144525.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 97.5 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Иргэний орлогын албан татвар	5000,0	8111,3	3111,3	162
Суутгагчийн ОАТатвар	36240	39659,3	3419,3	109
Хадгаламжийн хүүгийн орлого	13000	12787,7	-212,3	98
Бууны татвар албан татвар	5784,0	5930,0	146,0	103
Улсын тэмдэгт хураамж	5779,0	2962,5	-2816,4	51
Ойгоос хэрэглээний мод	42560,1	38446,3	-4113,8	90
Ан	16762,0	12048	-4714,0	72
Рашаан ус	330	350	20	106
Ашигт малтмалаас бусад	5432,5	5313,0	-119,5	98
Хог хаягдал	6786,0	2992,1	-3793,9	44
Түгээмэл тархацтай	2000,0	658,5	-1341,5	33

Төсөвт байгууллагын өөрийн орлого	130	457,8	-327,8	352
Хүү торгууль	8400,0	14808,9	6408,9	176
Нийт дүн	148203.6	144525.4	-3678.2	97.5

Нийт орлого 3678,2 мянган төгрөгөөр тасарсан. Үүнд Улсын тэмдэгтийн хураамж ойн нөөцийн орлого тасарсан болон банкуудын зээл олголт буурсан, бага дүнтэй зээлийн гэрээг нотариатаар баталгаажуулахгүй болсноос 2816.4 мянга, Ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөр сумын ИТХурлаас баталсан хуваарьтай модоо аж ахуйн нэгжүүд бэлдээгүй улмаас 4113.8 мянга, Ангийн төлбөрийн тодорхой хувь Байгаль хамгаалах санд төвлөрснөөс 4714.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна. Мөн Иргэний орлогын албан татвар 3111.3 мянга, Суутгагчийн орлогын албан татвар 3419.3 мянга, Хүү торгуулийн орлого 6408.9 мянган төгрөгөөр давж биелсэн нь Төсөвт байгууллага, Аж Ахуй Нэгжүүдэд татварын төлөвлөгөөт хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг төсөвт төвлөрүүлснээс төлөвлөгөө хэтэрсэн.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрт зориулан 2819848.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2674748.6 мянган төгрөгийг урсгал зардалд, 1451.0 мянган төгрөгийг бусад зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 2578535.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 23000.0 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 218313.5 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Хөрөнгө оруулалтын 8 төсөл, арга хэмжээнд 152181.2 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 143971.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 143971.4 мянган төгрөг буюу 94.6 хувьтай байгаа нь батлагдсан төсвөөс үнийн санал бага байснаас шалтгаалсан байна.

Нэмэлт төсөв: Хандив тусламж, гадаад төсөл хөтөлбөрөөр орлого байхгүй байна. Засгийн газрын нөөц сан /Засаг даргын нөөц хөрөнгө/-гаас 87554.8 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 38084.2 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2108.4 мянга, нийт 127737.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Тээвэр шатахууны зардалд 759.2 мянга, Дотоод албан томилолтод 9072.0 мянга, Бараа үйлчилгээний бусад зардалд 91203.8 мянга, Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 16722.6 мянга, Биет ба биет бус хөрөнгө худалдан авахад 9979.8 мянга нийт 127737.4 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэлгүй зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 4 горим сорил хэрэгжүүлжээ.

Аудитаар нийт 3678.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 3678.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 3678.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тэшиг сумын Засаг даргын санхүүгийн үйл ажиллагааг үр нөлөөтэй зохион байгуулах, дотоод хяналт, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна. Тухайлбал:

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 3678.1 мянган төгрөгөөр хангалтгүй биелсэн байна. Төлөвлөгөөний биелэлт хангаагүй орлогын нэр төрлөөр авч үзвэл Хөрөнгийн орлого 121.2, Улсын тэмдэгтийн хураамжийн орлого 2816.4, хог хаягдлын үйлчилгээний хураамж 3793.9, Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 1341.5, Ойн нөөц ашигласны төлбөр 4113.8, ан амьтны нөөц ашигласны төлбөр 4714.0, байгалийн ургамал ашигласны төлбөр 119.5 мянган төгрөгөөр тус тус тасалнаас болсон байна. Хувь хүний орлого 3419.3, үйл ажиллагааны орлого 3111.3, бууны албан татварын орлого 146.0, Ус, рашаан нөөц ашигласны төлбөрийн орлого 20.0, төсөвт байгууллагын өөрийн орлого 327.8, хүүгийн орлого 6408.8 мянган төгрөгөөр тус тус давсан байна.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангаар нийт 89751.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсний 1535.9 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоож, 61261.1 мянган төгрөгт албан шаардлага бичиж, зөрчлийг давтан гаргахгүй байх 26954.2 мянган төгрөгийн зөвлөмжийг тус тус хүргүүлсэн байна.

ТБОНӨХБАҮХА тухай хуулийг хэрэгжүүлээгүй шууд гэрээгээр худалдан авах босго үнээс давсан хүүхдийн хоолны материалын худалдан авалтыг тендер зохион байгуулаагүй ажилласан.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Тэшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 134 мэдээллийг хугацаанд нь, 14 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 6 мэдээллийг байршуулаагүй байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Урьд оны санхүүгийн аудитаар зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлага байхгүй.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Тэшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Тэшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу

илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Орлогын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 3678.1 мянган төгрөгөөр хангалтгүй биелсэн байна. Төлөвлөгөөний биелэлт хангаагүй орлогын нэр төрлөөр авч үзвэл Хөрөнгийн орлого 121.2, Улсын тэмдэгтийн хураамжийн орлого 2816.4, хог хаягдлын үйлчилгээний хураамж 3793.9, Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 1341.5, Ойн нөөц ашигласны төлбөр 4113.8, ан амьтны нөөц ашигласны төлбөр 4714.0, байгалийн ургамал ашигласны төлбөр 119.5 мянган төгрөгөөр тус тус тасланаас болсон байна. Хувь хүний орлого 3419.3, үйл ажиллагааны орлого 3111.3, бууны албан татварын орлого 146.0, Ус, рашаан нөөц ашигласны төлбөрийн орлого 20.0, төсөвт байгууллагын өөрийн орлого 327.8, хүүгийн орлого 6408.8 мянган төгрөгөөр тус тус давсан байна.

3.1.2 Эрсдэл:

Төлөвлөөгүй орлого орсноор зориулалт бус зардал гарах, төсвийн орлого тасарснаас эх үүсвэр дутагдах, хууль журам зөрчигдөх,

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухай төсвийн байгууллагын өөрийн орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах, жил бүрийн орлогын биелэлтэд дүн шинжилгээ хийж орлогыг бүрэн төлөвлөх, тасарсан орлого биелэх боломж байгаа эсэх талаар судалгаа хийж байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Саналгүй.

3.2. Төсвийн шууд захирагчтай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангаар нийт 89751.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсний 1535.9 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоож, 61261.1 мянган төгрөгт албан шаардлага бичиж, зөрчлийг давтан гаргахгүй байх 26954.2 мянган төгрөгийн зөвлөмжийг тус тус хүргүүлсэн байна.

3.2.2 Эрсдэл:

Хууль журам, зөрчигдөх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн шууд захирагч, санхүү, бүртгэлийн ажилтны сахилга хариуцлагыг сайжруулах, дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Саналгүй

3.3 Удирдлагатай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Сумын Засаг дарга Боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлэн Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх заалтыг зөрчин цэцэрлэгийн эрхлэгчид Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг дүгнэж үр дүнгийн урамшуулал олгох шийдвэр гаргасан нь тус хуулийн 30 дугаар зүйлд заасан аймгийн Засаг даргын бүрэн эрхийг хэрэгжүүлсэн байна.

3.3.2 Эрсдэл:

Хууль журам, зөрчигдөх.

3.3.2 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх заалтыг зөрчин цэцэрлэгийн эрхлэгчид Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг дүгнэж үр дүнгийн урамшуулал олгох шийдвэр гаргах

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Саналгүй

Төсвийн захирагч зөвшөөрсөн дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

БЭЛТГЭСЭН:

ГЭРЭЭТ АУДИТОР

П.ЭРДЭНЭЗУЛ

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	668949546,15	689277999,46
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	127704277,29	42622924,66
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	1882183,93	50153,47
31110	Төгрөг	1882183,93	50153,47
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	125822093,36	42572771,19
3121	Төгрөг	125822093,36	42572771,19
31211	Төрийн сангийн харилцах	125776375,56	42435600,55
31213	Арилжааны банк дахь харилцах	45717,80	137170,64
33	АВЛАГА	217690904,21	288502331,71
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	71498,10	591984,90
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		
33300	Татаас, санхүүжилтийн авлага	811850,00	4033620,00
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/		508737,71
335	Бусад авлага	216807556,11	283367989,10
3351	Байгууллагаас авах авлага	14493939,48	10649150,47
3352	Хувь хүмүүсээс авах авлага	202313616,63	272718838,63
35	БАРАА МАТЕРИАЛ	323554364,65	358152743,09
351	Түүхий эд материал	24701499,51	24663988,28
35130	Эм боох материал	24701499,51	24663988,28
35300	Бэлэн бүтээгдэхүүн		5192332,00
354	Хангамжийн материал	298552865,14	327996422,81
35410	Бичиг хэргийн материал	6219484,74	7486774,74
35420	Аж ахуйн материал	48735343,84	57185343,84
35430	Сэлбэг хэрэгсэл	4013100,00	5753100,00
35440	Түлш, шатах тослох материал	9605739,52	1620000,00
35460	Хүнсний материал	24439368,56	31397468,67
35470	Бусад хангамжийн материал	205539828,48	224553735,56
35600	Мал амьтад	300000,00	300000,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3206442353,74	3053533887,64
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3206442353,74	3053533887,64
392	Биет хөрөнгө	2984466819,74	2831621353,64
39201	Барилга, байгууламж, орон сууц	7606866945,13	7644208997,13
39202	Хуримтлагдсан элэгдэл	6253016851,49	6365198633,69
39203	Авто-тээврийн хэрэгсэл	338859343,00	395509343,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	223742914,25	241719518,86
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1640301220,00	1698000150,00
39206	Хуримтлагдсан элэгдэл	780697078,29	1025457996,15
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	198609845,59	251047133,43

Тэшиг сумын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

39208	Хуримтлагдсан элэгдэл	118850293,08	136471354,69
39214	Бусад үндсэн хөрөнгө	18176144,00	54176144,00
39215	Хуримтлагдсан элэгдэл	15090022,00	16623391,66
39216	Дуусаагүй барилга, байгууламж	550000000,00	550000000,00
39217	Ном	23050481,13	24150481,13
